

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгал) албан журмаар даатгуулах шимтгэлийн доод хэмжээг сарын 50 000 (тавин мянга) вонноос багагүй байхаар тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1-д зааснаас бусад нөхцөлөөр Бүгд Найрамдах Солонгос Улсад оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд (тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал) сайн дураар даатгуулах шимтгэлийн доод хэмжээг сарын 50 000 (тавин мянга) вонноос багагүй байхаар тогтоосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

4.Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт үүрэг болгосугай.

5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай" 05 дугаар тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг